



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 04 өдөр

Дугаар A/03

Сүхбаатар сум

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны  
27 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 7 дугаар зүйлийн 7.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 151 дүгээр зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг угтан сум орон нутагт ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын Үндсэн хууль батлалцсан АИХ-ын депутатуудад хүндэтгэл үзүүлэх, уулзалт ярилцлага хийх, санал хүсэлтийг хүлээн авч туслалцаа дэмжлэг үзүүлэх, Үндсэн хуулийг иргэд олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайланг 2018 оны 01 дүгээр сарын 15-ны дотор гарган ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ